



## БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 05 сарын 14 өдөр

Дугаар А/316

Булган сум

### Захирамжийн хавсралтад өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.1, 28.1.15 дахь заалт, Засгийн газрын 2024 оны 86 дугаар тогтоол, Булган аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны IV/25 дугаар тогтоолоор батлагдсан аймгийн Засаг даргын 2024-2028 онд хэрэгжүүлэн ажиллах “Булганы сэргэлт”, үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.1.1.2 дахь дэд заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мэдээлэл холбоо, камерын техник, технологийн мэргэжлийн ажиллах хүчний хүрэлцээ хангамж, дутагдалтай байдлыг харгалзан үзэж, Аймгийн Засаг даргын Тамгын газрын дэргэдэх “Теле камерын хяналтын дэд төв”-ийн бүтэц, ажиллах журмыг батлах тухай Засаг даргын 2025 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн А/108 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралтад “Систем хариуцсан инженер” гэснийг “Сүлжээний инженер” гэж өөрчилсүгэй.

2. “Теле камерын хяналтын дэд төв”-ийн туслах ажилтны албан тушаалын тодорхойлолтыг батлан, төрийн үйлчилгээний албан хаагчийн ТҮ-6 зэрэглэлээр цалинжуулахыг Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Наранбаяр)-д даалгасугай

ЗАСАГ ДАРГА  Д.ПҮРЭВ-ОЧИР

